




14th Story

Намхан Закхайтай уулзсан нь


Zacchaeus


Намхан Закхайтай уулзсан нь!

– 14th Story –



- Өгүүлэгч** Есүс шавь нартайгаа Иерихо руу явж байв. Олон хүн араас нь дагаж байсан бөгөөд Иерихо руу орох замд урдахаа харж чаддаггүй нэгэн сохор хүн юм ярьсаар ирэв.
- Сохор** Юунд ингэж шуугицгаана вэ? Юу болоо вэ? Хэн байгаа юм бэ?
- Олон хүн** Назарын Есүс. Тэр Есүс сая Иерихо руу ирж байна гэнэ.
- Сохор** Есүс? Тэр Есүс? Есүс багш! Эзэн! Надад нигүүлслээ буулгаач!
- Өгүүлэгч** Үй олон хүмүүсийн өмнө Есүсийг хажууд нь дагаж явсан хүмүүс ч гэсэн тэр дуу хоолойг сонслоо. Гэхдээ тэр сохор хүнд дуугүй бай гэж хэлсэн. Тэр сохор хүнийг Есүст саад болно гэж боджээ. Харин тэр сохор хүн улам чангаар хашгирсан.
- Сохор** Давидын үр удам аа! Алив! Надад нигүүлслээ буулгаач!
- Өгүүлэгч** Есүс тэр дуу хоолойг сонсоод түүнийг дагуулаад ир гэж хэлэв.
- Есүс** Надаас юу хүсээ вэ?
- Сохор** Эзэн минь, харж чаддаг болгооч.
- Есүс** За, нүдээ нээ. Итгэл чинь чамайг аварлаа.
- Өгүүлэгч** Есүс энэ үгийг хэлэнгүүт тэр сохор хүн харж эхэлсэн. Сохор хүн ихэд гайхсан бөгөөд Бурханыг магтан алдаршуулж Есүсийг дагалаа. Үүнийг харсан хүмүүс бүгд Бурханыг магтацгаалаа.
- Есүс болон түүний шавь нар олон түмэнтэй хамт Иерихо руу оров. Тэнд Закхай гэдэг татвар хураагч баян амьдардаг байжээ. Хүмүүсээс татвар хураадаг хүн болохоор олон хүн түүнд дургүй байв. Бас Закхай маш намхан хүн байсан.
- Есүсийг шавь нартайгаа өнгөрөн явах үед Закхай олон хүнийг харжээ. Тэгээд юу болохыг сонирхов.
- Олон хүн** Есүс! Есүс! Тэнд, тэнд Есүс байна~~
- Закхай** Есүс? Есүс гэж үү? хөөх! Би ч гэсэн уулзмаар байна, мм .. тэр тэнд байна. Тэнд. Хажуугаар чинь өнгөрч болох уу?





- Өгүүлэгч Закхай Есүстэй уулзахыг хүссэн боловч тэр хэтэрхий намхан болохоор олон түмэн дундуур явж чадахгүй байлаа.
- Закхай байзаарай, би явах хэрэгтэй байна. Өө би ч гэсэн Есүстэй уулзмаар байна, явах боломжгүй юм. Би дэндүү намхан... яах вэ?
- Өгүүлэгч Закхай яавал Есүстэй уулзаж чадахаа бодож байх үед, Есүс болон шавь нар нь явах замдаа инжир модыг олж харав.
- Закхай Болж байна! Би чадна аа! чадна! Би чадах ... ! аа!
- Өгүүлэгч Закхай модон дээр авирч байгаад Есүсийг харж чадахгүйдээ бухимдсан. Тэгээд хурдан мод руу авирахгүй бол Есүсийг харж чадахгүй нь гэж бодон санаа зовсон.
- Закхай одоо л мод руу авирах хэрэгтэй
- Закхай мод руу авирах үед Есүс модны зүг ирсэн. Тэгээд Закхайг өлийн хараад айлдав.
- Есүс Закхай! Модноос буугаад ир. Өнөөдөр танайд очиж хоноё
- Закхай айне өө өө за? Ойлголоо
- Өгүүлэгч Закхай Есүстэй уулзаад маш их гайхсан. Харин тэрнээс илүү Есүсийг ямар хүн болохыг таниад бүр их гайхав. Тэр Есүсийг яаж өөрийнх нь нэрийг мэдэж байсныг сонирхсон. Яагаад гэвэл урьд нь Есүстэй уулзаж байгаагүй юм. Харин Есүс Закхайг дуудахад яаравчлан модноос бууж ирсэн бөгөөд Есүсийн шавь нарыг гэр рүүгээ замчилсан.
- Гэтэл Есүсийг Закхайн гэр рүү орж байхыг харсан хүмүүс шивэр авир хийж эхэлсэн.
- Олон түмний нэг хүн Юу? Есүс Закхайн гэрт очсон гэж үү?
- Хүмүүс Закхай? Тэр чинь татвар хураагч ш дээ! Тэр бол гэм нүгэлтэн!
- Олон түмний нэг 2 Есүс хүнээ буруу таньж ...
- Олон түмний нэг эсвэл мэдэж байгаа ч тоохгүй байх нь ...
- Өгүүлэгч Хүмүүс ярилцаж байх үед Закхай модноос бууж ирсэн боловч тэр бүх яриаг бүгдийг сонсчээ. Хүмүүс түүний талаар шивэр авир хийхэд тэр гуниглав. Тэгээд Есүсийн хажууд очоод хэлсэн.

Закхай

Эзэн минь, Та яагаад манайд ирнэ гэж хэлснийг сайн мэдэхгүй юм. Гэхдээ энэ үгийг заавал хэлмээр байна. Миний хөрөнгөнийхөө хагасыг ядууст хувааж өгнө. Тэгээд надад бусдыг хуурсан зүйл байвал түүнийгээ 4 дахин нугалж төлнө.

Олон түмэн

Хөөх.. Хөөх!

Есүс

Закхай, чи үнэхээр бахархмаар юм. Өнөөдөр энэ гэрт аврал ирлээ. Энэ хүн ч гэсэн Абрахамын үр удам. Би энэ дэлхийд орхигдсон хүнийг олж аврахаар ирсэн юм.

